

03 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Багуудын хурлуудын товыг гарган хөдөөгийн 3 багийн хурлыг багийн төв дээр 2,4-р багуудын хурлыг сумын төвд УБ хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран сумын Засаг даргын 2021 оны ажлын тайлан цаашид хийх ажил болон нутгийн зөвлөлийн танилцуулга сумын 100 жилийн ой угтаж хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж иргэдийн санал бодлыг сонсож ажилласан. Мөн багуудын хурлуудаар тамгын газрын холбогдох мэргэжилтэн нар 2022 онд хийх ажлын талаар мэдээллийг иргэдэд танилцуулсан. Нийт давхардсан тоогоор 648 иргэн хамрагдсан.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоол “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах өдөр” –ийн арга хэмжээний хүрээнд 2022 оны 03-дугаар сарын 24-ны 16 цаг 00 минутад зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд сумын шуурхай штабын дарга С.Оюунжаргал Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, хэрхэн өөрийгөө хамгаалах талаар яриа сургалт зохион байгуулж ажиллаа. Хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлсийн жагсаалтыг гарган бүртгэж шалгасан. Мэргэжлийн анги бүлгийн 83 төрийн албан хаагчийн бэлэн байдлыг шалгахад 10 хүн чөлөөтэй, 4 хүн эрүүл мэндийн шалгаантай, ирц 83 хувьтай оролцлоо. Аранзны үзлэгт 80 төрийн албан хаагч хамрагдаж 65 албан хаагч бүрэн 15 албан хаагч 80 хувьтай бэлтгэж ирсэн байлаа.

Сумын засаг даргаар 2022 оны 02-р сарын 21 ны өдөр Эрэгтэйчүүдийн –Эрүүл мэндийн төлөө хамтдаа аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж нийт 14 ажлыг зохион байгуулахаар тусган ажилласан.

Аяны хүрээнд байгууллагуудын ажилчдын судалгааг гаргаж байгууллага бүрийн эрэгтэйчүүдийг “Зүрх судасны өвчний эрсдлийн үнэлгээ” хийж сүрьеэгийн асуумж судалгааг авч шаардлагатай ажилтнаас цэрний шинжилгээ авч, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Нийт 3 байгууллагын 31 ажилтанаас асуумж авч үзлэг шинжилгээг хийсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа аяны хүрээнд сумын ЗДТГ, Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран дотор, ЭХО, рентген, урологи, лаборант шинжилгээний эмч эмнэлгийн ажилчдыг өөрсдийн зардлаар ирүүлж 1 өдрийн үзлэгийг зохион байгуулсан. Нийт зардал 632,0 мянган төгрөгийг гарган ажилласан.

Хөдөлмөр халамжид бүртгэлтэй, хүнсний эрхийн талоноор үйлчлүүлдэг гэр бүлийн эрэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах талаар нийгмийн халамжийн байцаагчтай хамтран нэрсийг гаргаж үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна. Урьдчилан сэргийлэх үзлэг, сахарын шинжилгээ, В,С вирусын шинжилгээ, шээсний шинжилгээ, цээжний рентген зураг, цэрний шинжилгээг авч байна. Үүнд нийт давхардсан тоогоор 32 хүн үйлчлүүлсэн.

Малчин эрэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг, идэвхтэй илрүүлэлтэнд хамруулах талаар “Эрчүүдээ хайрлая, эрүүл мэндийг нь хамгаалъя” аяныг өрнүүлж зүрх судасны эрсдлийг тодорхойлох үнэлгээ болон амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулж шаардлагатай үйлчлүүлэгчээс сорьцын шинжилгээг авсан. Эрсдлийн үнэлгээг нийт 178 эрэгтэйчүүдээс, амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлэх асуулжинд 56 эрэгтэйчүүдийг хамруулсан бөгөөд 11 хүнээс цэрний шинжилгээ авч илгээсэн.

Илүүдэл жингүй –Эртэч монгол аяны хүрээнд сумын Засаг даргын 2022 оны 03

сарын 01 ны өдрийн А/29 тоот захирамжаар ажлын хэсэг томилж, нэгдсэн төлөвлөгөө гарган сумын хэмжээнд бүх нийтийн дасгал хөдөлгөөнийг 1-5 дахь өдөр бүр өглөө 06-07 цаг хүртэлх хугацаанд соёлын төвд нэгдсэн зохион байгуулалттайгаар тогтмол хийж хэвшээд байна.

Төрийн үйлчилгээний чиглэлээр:

Е-Mongolia лавлагаа нийт 10 иргэн авснаас үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 5, гэрлэлтийн лавлагаа 4, нийгмийн даатгалын лавлагаа 1 –ийг гаргасан. 1-р улирлын өргөдөл гомдол 11 ирсэн. Үүнээс хугацаа болоогүй 8, шийдвэрлэгдсэн 3 байна.

Улсын бүртгэгч: төрсний бүртгэл 6, гэрлэлт 2, овог эцэг эхийн нэр, нэр өөрчилсний 1, нас барсан 2, хаяж гээгдүүлсэн иргэний үнэмлэх авах хүсэлт 2, шилжилт хөдөлгөөн 4, төрсний гэрчилгээ дахин олголт 3, улсын бүртгэлийн лавлагаа 7 иргэн, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл 1, газар өмчлөх эрхийн улсын бүртгэл 20 зээлийн гэрээ 3 –ийг бүртгэж баталгаажуулсан байна.

Хоёр: Хууль эрх зүйн чиглэлээр:

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, ИТХ, Цагдаагийн Хэсэг, ЗДТГ хамтран “Зөвийг зөвлөө” Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 3 сарын 17 төсөвт байгууллага багуудын дунд Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон архины хор уршгийн талаар мэдээлэл хийсэн. Нийт 10 багийн 70 тамирчид, үзэгч 67 иргэн нийт 137 хүн арга хэмжээнд оролцсон. Мөн цагдаагийн хэсэг ЗДТГ газар хамтран уг арга хэмжээг сурталчилан таниулах ажлыг зорилтот өрх болон ЕБС-ийн 10-12 –р ангийн сурагчдад хийж мэдээлэл хүргэн ажилласан.

Гурав: Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын Засаг даргын нөөцөөс нохой устгалын ажилд 1408000, багуудын цолгүй бөхчүүдийн барилдаанд 370000, эмэгтэйчүүдийн зөвлөлийн эх үрсийн баяраар зохион байгуулсан Гар бөмбөгийн тэмцээнд 500000 мян нийт 2278,0 мянган төгрөгийг гарган дэмжиж ажилласан.

Дөрөв: Нийгмийн бодлогын хүрээнд: Ландовнер компанийн ажилчдад хүн ам зүйн судалгаа мэдээлэл гаргаж өгсөн

Нийгмийн бодлогын мэргэжилтэний цахим сургалтад хамрагдаж НАМС программын талаар суралцсан. 108-н дуудлагын гомдлын дагуу хариуцагчид зохих арга хэмжээг авч ажилласан. 108-н дуудлагын гомдлын дагуу КЕЙС бүртгэл хөтлөн арга хэмжээ авч кейсийг хааж Аймгийн Хүүхэд хамгааллын багт шилжүүлсэн. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Харилцан хүндэтгээ” аяны хүрээнд төсөвт 5-н байгууллагын ажилчдад жендерийн тэгш харилцааны талаарх мэдээлэл хүргэж зураг авч аянд нэгдэцгээсэн.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн тэтгэвэр 103 иргэнд 28,792,212 төгрөг

Нийгмийн халамжийн тэтгэмж 124 иргэнд 11,465,6817 төгрөг

“Цалинтай ээж”-ийн тэтгэмж 273 иргэнд 13,187,156 төгрөг

Жирэмсэн эхийн тэтгэмж 26 иргэнд 1,003,272 төгрөг

Хүүхдийн мөнгө 1736 хүүхдэд 173,600,000 төгрөгийн олголт хийгдсэн байна.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сарын 21-нд хуралдуулж ахмадын асаргаа сунгах 2 иргэний хүсэлт, шинээр асаргаанд орох 1 иргэний хүсэлт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сунгах 1 иргэн, нийт 4 иргэний хүсэлтийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн.

ХЭБҮ-нд энэ сард 32 өрхийн 153 иргэний 1736,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

2022 хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар ФВ: Мөнххаан сумын нэгдсэн зар зарлалын групп цахим хуудсанд мэдээллийг нийтэлсэн.

2022.04.12-нд Сумын төвд 2, 4-р багийн хөдөлмөрчдийн хуралд Нийгмийн халамжийн бодлого, 2022 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийн мэдээлэл хийсэн. Нийт 300 иргэн хамрагдсан. 2022.04.04-04.16-ны хүртэл хөдөө 5,3,1-р багийн хуралд явж мэдээлэл хийсэн. 5-р баг 37 иргэн, 3-р баг 24 иргэн, 1-р баг 80 иргэн хамрагдсан. Нийт 441 иргэнд мэдээлэл өгсөн.

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангийн дансанд 1 иргэн 800000 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тав :ЕБС. Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд боловсролын салбарт томоохон хөрөнгө оруулалт хийж, 20 сая төгрөгний мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмжийг аймгийн Засаг даргын орлогч Г.Мөнхзаяа, НБХ-ийн дарга Р.Алтаннар, БШУГ-ын дарга Л.Байгалмаа нар гардуулж өглөө.Багш, сурагчдад маань стандартад нийцсэн сургалтын орчныг бүрдүүлэхэд үзүүлж буй энэхүү томоохон хөрөнгө оруулалт хийлээ. Өсвөр үеийн ААШ волейболын тэмцээнд багш Д.Батсүх дасгалжуулсан баг тамирчид амжилттай оролцож

- 🏆 Бага насны ангиллын эрэгтэй төрөлд-2-р байр Мөнгөн медаль
- 🏆 Ахлах насны ангиллын эрэгтэй төрөлд - 2-р байр Мөнгөн медаль
- 🏆 Ахлах насны ангиллын эмэгтэй төрөлд -3-р байр Хүрэл медаль

БАГИЙН ДҮНГЭЭР:

- 🏆 Бага насны ангилал -ГУТГААР байр
- 🏆 Ахлах насны ангилал -ДЭД байр тус тус эзэллээ.

Насанд хүрэгчдийн ААШ-100 н буудалт даамны тэмцээнд Мэдээллийн технологийн багш М.Түвшинжаргал 1-р байр эзэлж Алтан медаль ,Монгол хэл уран зохиолын багш А.Даваасүрэн 1-р байр алтан медаль тус тус хүртсэн сайхан амжилтыг үзүүллээ.Мөн сум орон нутгаа төлөөлөн оролцсон манай сургуулийн төгсөгч Э.Энхбаатар 2-р байр мөнгөн медаль, У.Пүрэвбат 3-р байр хүрэл медалиар тус тус шагнагдлаа.

ААШ-100-н буудалт даамны тэмцээнд М.Түвшинжаргал багшийн бэлтгэсэн

•1а ангийн сурагч Г.Төгөлдөр 1-р байр Алт ,У.Пүрэвбат 1-р байр Алт

- 🏆 •1а ангийн сурагч Н.Чинхүслэн 2-р байр Мөнгө
- 🏆 •7в ангийн сурагч Б.Дугарлхам 2-р байр Мөнгө
- 🏆 •7б ангийн сурагч Б.Маргад-Эрдэнэ 2-р байр Мөнгө
- 🏆 •7в ангийн сурагч Ө.Эгшиглэн "Шилдэг тоглогч" шагналаар тус тус шагнагдаж багийн дүнгээр "ГУТГААР" байр эзэллээ.

БУЗАН-ийн 14 хоногийн аяны хүрээнд , хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохион явуулсан" **Хувь хүний хөгжил, чиг хандлага**" сэдэвт лекц хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 137 хүүхдийн эцэг эх хамрагдлаа. Өсвөр үеийн ААШ-Чөлөөт бөхийн болон Самбо бөхийн тэмцээн Баруун-Урт хотод амжилттай зохион байгуулагдлаа.

Чөлөөт бөхийн төрөлд А.Батхишиг багшийн бэлтгэсэн

- 🏆 •8в ангийн сурагч Х.Пагмэджав Мөнгөн медаль
- 🏆 •8б ангийн сурагч Б.Тэгшжин Мөнгөн медаль
- 🏆 •10б ангийн сурагч Э.Дашпунцаг Мөнгөн медаль

Самбо бөхийн .Батхишиг багшийн бэлтгэсэн

- 86 ангийн сурагч Б.Тэгшжин Мөнгөн медаль •
- 11а ангийн сурагч Б.Тэлмүүн-Од Мөнгөн медаль
- 11а У.Баасанжав Мөнгөн медаль
- 86 ангийн сурагч Б.Тэгшжин "ШИЛДЭГ ТАМИРЧИН"өргөмжлөл тус тус хүртлээ.

"Энтерпренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх" 2021-2022 оны хичээлийн жилд хэрэгжиж сургалтын үйл ажиллагаа үргэлжлэн явагдаад сургалтын 1-р ээлж амжилттай төгсөж хаалтын үйл ажиллагаагаа хийж сертификат гардуулах ,тэтгэлэгт оролцогчид өөрсдийн бичсэн төслөө танилцуулах арга хэмжээ зохион байгуулагддаа. Тус сумаас уг төслийн тэтгэлэгт насанд хүрэгчдийн ангийн 2 төсөл шалгарсан. ЕБС-ийн сурагчдын тэтгэлэгт оролцох 1 төсөл сайжруулалтыг хийж хүргүүлсэн.

Шалгуурт суурилсан үнэлгээний арга зүй"-г судалж, сургалтын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор судлагдахууны багууд ахлах, дунд ангийн 35 багш **"УРИЛГАТ"**хичээлийг зохион байгуулж ажиллалаа. БЧШ-5 төслийн хүрээнд Монгол Улсын гавьяат багш Г.Батболдыг урьж " Сурлагын амжилтын хяналт-шинжилгээ, үнэлгээ, математикийн онол арга зүй, сурлагын хоцрогдлыг арилгах арга зам "сэдэвт сургалтанд бага ангийн 18 багш, сургалтын менежер нар хамрагдлаа.

БЧШ-5 төслийн хүрээнд бага ангийн сурагчдын унших, сонсох, чээжлэх чадварыг хөгжүүлэх үүднээс 17 бүлэг давхардсан тоогоор улиралд 34 шүлэг чээжлэж байна.

Математикийн хичээлээр бага ангийн 17 багш **"Самбар төлөвлөлт"**-ийг хэн сайн ашиглах бэ уралдаанд бүгд идэвхтэй оролцов.

Зургаа: Хүүхдийн цэцэрлэг: Сургалтын чанарыг сайжруулах, хоцрогдол нөхөх төлөвлөлтийн дагуу үйл ажиллагаа хэвийн явагдлаа. Багш нарын, хоцрогдол нөхөх туршлагаа танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, багш П.Оюунтуяа, Б.Урансайхан нарын арга зүй үр дүнтэй, цэгцтэй , зөв зохион байгуулалттай гэж үнэлэгдлээ. Судар эгшиглэн 2022 төслийн үйл ажиллагаанд хамт олноороо оролцож, эхний шатыг байгууллага дээрээ зохион байгуулж байна. Нийт 20 чиглэлийн ном уншиж, тэмдэглэл хөтлөхөөс 3 дахь чиглэлийн номоо уншиж байна. Үүний үр дүнд багш нарын ажлын цаг ашиглалт сайжирч, мэдлэгийн түвшин ахиж байна. Бүлгүүдийн сургалтын төвүүдийн шинэчлэл хийж, багш бүр бүтээлчээр гар урлал ашиглан сургалтын хэрэглэгдэхүүний баяжилт хийлээ. Нийт 480 гаруй тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүн хийжээ.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд цэцэрлэг тус бүрт 10 сая төгрөгийн тоглоом наадгайг шийдвэрлэсэн. Стандартад нийцсэн сургалтын орчныг бүрдүүлэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэгдсэн энэхүү хөрөнгө оруулалтыг хүлээн авч, сургалт үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

2. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал.

2.1. "Судар эгшиглэн 2022" төслийн эхний шатыг байгууллага дээрээ амжилттай зохион явуулж, материалыг аймгийн номын санд илгээсэн ба байгууллагын төрөлд ТЭРГҮҮН байр эзэлсэн.

2.2. Аймгийн ҮЭ-ээс зохион явуулсан "Манай гэр бүлийн тэгш эрх, оролцоо" ЭССЭ бичлэгийн уралдаанд амжилттай оролцож, эрхлэгч Д.Ариунмөнхийн бичсэн ЭССЭ аймагт ТЭРГҮҮН байр эзэлсэн байна.

2.3. Аймгийн ҮЭ үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд ҮЭ-ийн анхан шатны байгууллагуудын дунд зохиогдсон волейболын тэмцээнд,тус цэцэрлэгийн эрэгтэй баг амжилттай оролцон хүрэл медаль хүртэж, багш М. Шинэзуун шилдэг довтлогчоор шалгарсан амжилт үзүүлсэн байна.

Долоо: Соёл: 03-р сард соёл урлагийн нэгдсэн арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 980 үзэгчдийг гадны тоглолт 3 удаа зохион байгуулагдаж 450 үзэгчдийг хамрууллаа.

Сумын засаг даргын тамгын газар соёлын төв хамтран Иргэдээ сонсоё уулзалт өдөрлөгийг хөдөөгийн 4, төвийн 1 багт зохион байгуулан соёлын төвийн үйл ажиллагааны тайланг танилцуулан номын сан соёлын өв, угийн бичгийн сургалт, соёлын арга хэмжээг зохион байгуулан үйл ажиллагаандаа 500 гаруй иргэдийг хамруулж 3-р сард нийт 1930 иргэдэд соёлын үйлчилгээг хүргэн ажилласан.

Сумын засаг даргын 2022/03/01 ны өдрийн А/29 тоот захирамжаар Илүүдэл жингүй-Эртэч монгол аяны нээлтийн арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллаж иргэдэд заал танхимаар үйлчлэх бүжгийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах ажлуудыг хийн ажиллаж байна. Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн дэмжлэгтэйгээр номын санд 5 сая төгрөгийн номын баяжилт хийгдсэн.

Соёл урлагийн үйлчилгээ:

Номын сангаас Ээждээ захидал бичээрэй уралдааныг зохион байгуулж нийт 25 захидал ирж хүүхдийн насанд хүрэгчдийн төрлөөр эхний 3 байрыг шалгаруулж 150,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. Эмэгтэйчүүдийн баярт зориулан Тайзны караоке тэмцээнийг зохион байгуулж 15 баг оролцсоноос төрийн болон төрийн бус байгууллага, багийн иргэдийн төрөлд эхний 6 байрыг шалгаруулж мөн төрөл бүрт эхний 1-р байрыг шалгаруулж шагналын зардалд 700,000 төгрөгийг зарцууллаа

Монгол цэргийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, соёлын өв уламжлалыг сурталчлах зорилгоор “Хийморьтой үдэш” уралдааныг зохион байгуулан нийт 9 баг оролцож шагналын зардалд 350,000 төгрөгийг зарцууллаа.

Хөдөөгийн 4 багийн хуралд хамтран оролцож багийн иргэдэд номын сангийн үйлчилгээ, соёл урлагийн үйлчилгээг хүргэн ажилласан .

Бүжгийн дугуйланд 56 сурагч зумбо бүжгийн сургалтанд 25 насанд хүрэгчид, цэнгээнт бүжгийн сургалтанд 39 насанд хүрэгчид , хөгжмийн сургалтанд 23 сурагчид, цахилгаан хөгжмийн сургалтанд нийт 5 насанд хүрэгчид хамрагдан суралцаж байна. Номын сангийн дэргэдэх “Даль жигүүр” уншигчийн клубын үйл ажиллагаанд 46 сурагчид хамрагдаад байна.

Найм: Эрүүл мэндийн чиглэлээр: 2022 оны 03 сарын 24-ны байдлаар 75 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 12 насанд хүрэгчид, 63 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

2 -3 сард “Архи согтууруулах ундааны хор уршиг” “Аюулгүй бай – Эрүүл бай” аяны төлөвлөгөө гарган ажиллаж тайланг хугацаанд нь илгээсэн. “Идэвхтэй илрүүлэлтийг чанартай зохион байгуулж сүрьеэг илрүүлье” 1 сарын аян зохион байгуулж сүрьеэгээр өвдсөн 24 хүний өрхийн болон дам хавьталыг судалж шаардлагатай 11 хүнээс цэрний шинжилгээ авч илгээж, асуумж судалгаанд 45 хүнийг хамруулсан.

“Эрэгтэйчүүдийн – эрүүл мэндийн төлөө хамтдаа аяны хүрээнд нийт үзлэг хийдэг эмч нартай хамтран зүрх судасны өвчний эрсдлийн үнэлгээг хийх асуумж судалгааг 178 хүнээс бөглүүлж шаардлагатай хүнээс элэгний В,С болон сахарын шинжилгээ авсан. В вирусын 1-р тунд 100 хамрагдсан.

Амбулаторийн үзлэг 684 урьдчилан сэргийлэх үзлэг 96 байна. Ковид-19 вакцины 1-р тунд 3614/3355 хүн буюу 92.8%, 2-р тунд 3614/3131хүн буюу 86.6% , 3-р тунд хүн 2667 хүн хамрагдахаас 1484 хүн буюу 55,6%, 4-р тунд 210 хүн буюу 14.1% хамрагдаад байна.

Түргэн тусламжийн дуудлага 108 ирснээс алсын дуудлага–14, ойрын дуудлага 94 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Ес: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

ХАА-н тасаг: Бэлчээр ашиглах журам боловсруулж хууль зүйн зөвөлгөө авахаар холбогдох газарт хүргүүлээд байна.Сумын төвийн хязгаарлалтыгн бүсэд буй мал бүхий иргэнтэй гэрээ байгуулах ажил зохион байгуулж мал бүхий 8 иргэн, сумын засаг даргатай гэрээ байгуулаад байна. Уул уурхайтай сумдын бүтээгдхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжийн судалгаа гаргаж, ажлын хэсэг байгуулж төлөвлөгөө гаргаж засаг даргаар батлууллаа. Үлийн цагаан огтонотой тэмцэх ажлын хүрээнд “Ногоон газар тариалан”ТББ-тай 3 тн оготно устгалын бэлдмэл авах гэрээг байгуулаад байна.

Арав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 01 албан даалгаврын дагуу төлөвлөгөө гарган хээрийн түймрийн урьдчилан сэргийлэх талаар 3-н группт сэрэмжлүүлэг мэдээг цахим хэлбэрээр 3 удаагийн давтамжтай мөн 5-н багийн иргэдийн нийтийн хурлуудад 305 иргэнд санамж, зөвлөмж өгч гарын үсгийн баталгааг авч ажиллаж байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.